| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | 00.00                           | 00.00                 | 00.00                 | 00.00                                  |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               | 00.00                           | 00.00                 | 00.00                 | 00.00                                  |
| D08 | Тайлант үеийн үр дүн                             | 00.00                           | 00.00                 | 192,834,858.71        | 192,834,858.71                         |
| D09 | <b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>21,040,000.00</b>            | <b>3,246,926.63</b>   | <b>958,464,299.72</b> | <b>982,751,226.35</b>                  |

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт  | Тайлант оны           |                       | Зөрүү               | Хувь          |
|-----------------------|---|-----------------------|-----------------------|---------------------|---------------|
|                       |   | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл             |                     |               |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                        | <b>640,042,700.00</b> | <b>632,648,484.14</b> | <b>7,394,215.86</b> | <b>98.8%</b>  |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>640,042,700.00</b> | <b>632,648,484.14</b> | <b>7,394,215.86</b> | <b>98.8%</b>  |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                          | <b>639,507,100.00</b> | <b>632,348,484.14</b> | <b>7,158,615.86</b> | <b>98.9%</b>  |
| 2101                  | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                        | <b>460,073,185.00</b> | <b>460,073,184.00</b> | <b>1.00</b>         | <b>100%</b>   |
| 210101                | Үндсэн цалин  | 362,967,513.00        | 362,967,512.76        | 0.24                | 100%          |
| 210102                | Нэмэгдэл  | 88,055,972.00         | 88,055,972.00         | 0.00                | 100%          |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт   | 9,049,700.00          | 9,049,699.24          | 0.76                | 100%          |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>           | <b>101,170,380.00</b> | <b>96,970,379.14</b>  | <b>4,200,000.86</b> | <b>95.8%</b>  |
| 210201                | Тэтгэврийн даатгал  | 101,170,380.00        | 82,710,409.49         | 18,459,970.51       | 81.8%         |
| 210202                | Тэтгэмжийн даатгал  | 00.00                 | 3,613,400.14          | -3,613,400.14       |               |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал   | 00.00                 | 2,890,720.10          | -2,890,720.10       |               |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал  | 00.00                 | 705,077.23            | -705,077.23         |               |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал   | 00.00                 | 7,050,772.18          | -7,050,772.18       | 100%          |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                | <b>56,928,967.00</b>  | <b>57,108,965.00</b>  | <b>-179,998.00</b>  | <b>100.3%</b> |
| 210301                | Гэрэл, цахилгаан  | 6,021,067.00          | 6,201,067.00          | -180,000.00         | 103.0%        |
| 210302                | Түлш, халаалт   | 49,086,800.00         | 49,086,800.00         | 0.00                | 100%          |
| 210303                | Цэвэр, бохир ус   | 1,821,100.00          | 1,821,098.00          | 2.00                | 100%          |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                         | <b>17,333,368.00</b>  | <b>15,000,900.00</b>  | <b>2,332,468.00</b> | <b>86.5%</b>  |
| 210401                | Бичиг хэрэг   | 5,385,091.00          | 5,637,200.00          | -252,109.00         | 104.7%        |
| 210402                | Тээвэр, шатахуун  | 3,905,000.00          | 3,902,041.00          | 2,959.00            | 99.9%         |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                              | 3,293,200.00          | 3,293,182.00          | 18.00               | 100%          |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал       | 293,925.00            | 113,925.00            | 180,000.00          | 38.8%         |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                     | 4,456,152.00          | 2,054,552.00          | 2,401,600.00        | 46.1%         |
| 2106                  | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                        | <b>2,436,500.00</b>   | <b>1,702,407.00</b>   | <b>734,093.00</b>   | <b>69.9%</b>  |
| 210601                | Багаж, техник, хэрэгсэл   | 840,000.00            | 839,907.00            | 93.00               | 100%          |
| 210603                | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                                    | 562,500.00            | 562,500.00            | 0.00                | 100%          |
| 210604                | Урсгал засвар   | 1,034,000.00          | 300,000.00            | 734,000.00          | 29.0%         |
| 2107                  | <b>Томилолт, зочны зардал</b>                                   | <b>159,000.00</b>     | <b>159,000.00</b>     | <b>0.00</b>         | <b>100%</b>   |
| 210702                | Дотоод албан томилолт   | 159,000.00            | 159,000.00            | 0.00                | 100%          |
| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>1,039,300.00</b>   | <b>967,249.00</b>     | <b>72,051.00</b>    | <b>93.1%</b>  |

|             |  |                       |                       |                   |              |
|-------------|--|-----------------------|-----------------------|-------------------|--------------|
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 437,300.00            | 404,000.00            | 33,300.00         | 92.4%        |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 280,000.00            | 280,000.00            | 0.00              | 100%         |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 120,000.00            | 120,000.00            | 0.00              | 100%         |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 120,000.00            | 103,249.00            | 16,751.00         | 86.0%        |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 22,000.00             | 00.00                 | 22,000.00         |              |
| 210807      | Газрын төлбөр  | 60,000.00             | 60,000.00             | 0.00              | 100%         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>366400.00</b>      | <b>366400.00</b>      | <b>0.00</b>       | <b>100%</b>  |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 366,400.00            | 366,400.00            | 0.00              | 100%         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>535600.00</b>      | <b>300000.00</b>      | <b>235,600.00</b> | <b>56.0%</b> |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>535,600.00</b>     | <b>300,000.00</b>     | <b>235,600.00</b> | <b>56.0%</b> |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 535,600.00            | 300,000.00            | 235,600.00        | 56.0%        |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>640,042,700.00</b> | <b>632,648,484.14</b> | -                 |              |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>640,042,700.00</b> | <b>632,648,484.14</b> | -                 |              |
| 131001      | Улсын төсвөөс санхүүжих  | 640,042,700.00        | 632,648,484.14        | -                 |              |

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Тайлант оны |                       | Зөрүү                  | Хувь |
|-----------------------|--|-------------|-----------------------|------------------------|------|
|                       |  | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл             |                        |      |
| I                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             |             | <b>126,374,520.00</b> | <b>-126,374,520.00</b> |      |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   |             | <b>126,374,520.00</b> | <b>-126,374,520.00</b> |      |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               |             | <b>126,046,520.00</b> | <b>-126,046,520.00</b> |      |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              |             | <b>4,369,700.00</b>   | <b>-4,369,700.00</b>   |      |
| 210401                | Бичиг хэрэг  |             | 1,788,100.00          | -1,788,100.00          |      |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            |             | 180,000.00            | -180,000.00            |      |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          |             | 2,401,600.00          | -2,401,600.00          |      |
| 2106                  | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             |             | <b>38,168,000.00</b>  | <b>-38,168,000.00</b>  |      |
| 210602                | Тавилга  |             | 37,434,000.00         | -37,434,000.00         |      |
| 210604                | Урсгал засвар  |             | 734,000.00            | -734,000.00            |      |
| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      |             | <b>33,300.00</b>      | <b>-33,300.00</b>      |      |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж |             | 33,300.00             | -33,300.00             |      |
| 2109                  | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | -           | <b>83,475,520.00</b>  | <b>-83,475,520.00</b>  |      |
| 210901                | Бараа үйлчилгээний бусад зардал                                      |             | 83,475,520.00         | -83,475,520.00         |      |
| 213                   | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | -           | <b>190,000.00</b>     | <b>(190,000.00)</b>    |      |
| 2132                  | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  |             | <b>190,000.00</b>     | <b>(190,000.00)</b>    |      |
| 213209                | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              |             | 190,000.00            | (190,000.00)           |      |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 93 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь “Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх, мэдээллийг хэрэглээнд оруулах дундын өгөгдлийн системийг бий болгон хөгжүүлэх, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг сайжруулах, мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах” гэсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 820,504.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,205.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6,564.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 192,834.8 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт         |
|---|------------------|------------------|------------------|
| Б   | 1                | 2                | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                                    | 0.0              | 0.0              | 0.0              |
| Авлага  | 9,488.7          | 38,634.0         | 29,145.3         |
| Бараа материал                                    | 33,544.0         | 47,440.5         | 13,896.5         |
| Үндсэн хөрөнгө                                    | 746,883.7        | 896,676.8        | 149,793.1        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>789,916.4</b> | <b>982,751.2</b> | <b>192,834.8</b> |
| Өр төлбөр   | 0.0              | 0.0              | 0.0              |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 789,916.4        | 982,751.2        | 192,834.8        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>789,916.4</b> | <b>982,751.2</b> | <b>192,834.8</b> |

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 29,145.3 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагаас авах авлага 37,434.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бусад зардлын тооцооны авлага 4,988.7 мянга, хувь хүмүүсээс авах авлага 3,300.0 мянган төгрөгөөр барагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 47,440.5 мянган төгрөг болж 13,896.5 мянган төгрөгөөр өссөн нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас шилжүүлэн авсан тусгай зориулалттай материал, сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материал зарцуулагдаагүй үлдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 896,676.8 мянган төгрөг болж 149,793.1 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан 179,708.3 мянга, балансас баланс шилжүүлэн авсан 1,638.8 мянга, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 323.0 мянга, нийт 181,669.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нэмэгдэж, тайлант онд 31,467.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 982,751.2 мянган төгрөг болж 192,834.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 15,913.0 мянган төгрөгөөр буюу 20.4 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 4,120.8 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна. Үүнд цалин, хөлс болон нэмэгдэл урамшил болон бараа үйлчилгээний бусад зардал нөлөөлсөн байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 821,006.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 821,006.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 180,964.0 мянган төгрөгийн барилгын дээврийн их засварын төсвийг бууруулж, 640,042.7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 946,049.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 946,049.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 640,042.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 175,314.0 мянган төгрөг, нийт 815,356.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 807,961.5 мянган төгрөгийг зарцуулж 7,394.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 807,961.5 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансаар 130,692.9 мянган төгрөгийн орлого орж 130,692.9 мянган төгрөгийн зарлага гарсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тавилга эд хогшлын зардлаас архивын нягтруулсан шүүгээ бэлтгэхээр тендер зарлаж “Лүндээ-Очир” ХХК-тай гэрээ байгуулан 37,434.0 мянган төгрөгийг шилжүүлж авлагаар бүртгэсэн байна. Дараагийн аудитаар хөрөнгө биетээр ирсэн эсэхэд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |     | Үүнээс    |     |               |     |                 |     |         |     |
|-----|-------------------------------------|----------------------|-----|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|     |                                     |                      |     | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|     |                                     | Тоо                  | Дүн | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| 1   | Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс | -                    | -   | -         | -   | -             | -   | -               | -   | -       | -   |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Б.ОДГЭРЭЛ/

2022 оны 02 сарын 24-ны өдөр